

**НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2023 оны 12 дугаар сарын 08

Улаанбаатар хот

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв сая төгрөгөөр	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
1. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ							
Стратегийн төлөвлөгөөний зорилго-1: Соёл урлагийн хөгжлийг зорилтот түвшинд хүргэнэ.							
1.1	"Нүүдэлчин" олон улсын фестивалд оролцох	340.8	Оролцогчдын тоо	184	200	"Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивалд нийслэлийг төлөөлж оролцох өвлөн уламжлагчдыг 9 дүүргийн 290 гаруй ардын авьяастан өвлөн уламжлагчдаас сонгон шалгаруулж, 12 угсаатныг 11-83 насны 270 шилдэг өвлөн уламжлагчид Нүүдэлчин наадамд оролцлоо. Халх, Боржигон, Баяд, Буриад, Торгууд, Захчин, Дархад, Дөрвөд, Казак, Цаатан угсаатны өв уламжлалыг тус тусын онцлог шижир хэв шинжээр нь дамжуулж "Угсаатны тойромт наадгай"-г Нийслэлийн отог дээр зохион байгуулж, аймаг, нийслэлийн чуулга, хамтлагууд өдөрт 6 удаа отогийн тоглолт хийж, нэгдсэн 1 тоглолтыг хамтран зохион байгуулсан. Морин хуур, икэл, домбор, товщуур, цуур хөгжмийн 7 өвлөн уламжлагч 512 ардын хөгжмийн их найралд оролцож, өвлөн уламжлагчид эх хэл аман уламжлал, ардын язгуур урлаг, уламжлалт арга ухаан, уламжлалт гар урлалын төрөл буюу нийт 4 ай савын 17 төрлөөр оролцов. Наадамд Нийслэл болон 21 аймаг, ӨМӨЗО, Халимаг, Тува, Буриад, Киргиз, Турк, Унгар, Казакстан, Саха, Солонгос зэрэг 10-н улсын нийт 1100 гаран уран бүтээлчид оролцсон бөгөөд 120,000 иргэд, жуулчид үзэж сонирхсон. Мөн тус наадмын нийтлэг үйлчилгээ, тээвэр ложистикийн ажлуудыг хариуцан ажиллаж, удирдамжийн дагуу үзэсгэлэнгийн гэр барьж, түүнд шилдэг гар урлалын өвлөн уламжлагчид бүтээлийн үзэсгэлэн гаргасан.	100
1.2	Азийн хотуудын ардын урлаг, гар	144.0	Оролцогчдын тоо	-	150	Азийн хотуудын ардын урлаг, гар урлалын наадамд дэлхийн 20 орны 280 орчим төлөөлөгчид өөрсдийн орны үндэсний өв	100

	урлалын наадмыг зохион байгуулах					соёл, онцлогт суурилсан олон улсын түвшний шилдэг бүтээлүүдээр оролцож, үйл ажиллагааг олон нийтэд түгээн сурталчилж ажиллав.Тухайлбал: Монгол, БНХАУ, ОХУ, БНСУ, Индонези, Малайз, Филиппин, Энэтхэг, Япон, Иран, Тайланд, Польш зэрэг 22 орноос 160 уран бүтээлч Улаанбаатар хотод хүрэлцэн ирж, цахимаар 120 уран бүтээлч оролцсон. Түүнчлэн 6 улсын 20 гаруй, Монголын 300 гаруй гар урлаач оролцож, Сүхбаатарын талбайд бүтээлээ дэлгэн үзүүллээ. Үүнээс Гранпри шагналаар БНХАУ-ын ӨМӨЗО-ны уран бүтээлч дуучин Дэлхий шалгарч "АЛТАН ЦОМ"-ын эзэн болж, азийн зургаан хотын гар урлаачид наадмын ТАЛАРХАЛ хүртээсэн. Наадмын үйл ажиллагааг НЗДТГ, НЖДҮҮДТ НӨҮГ, НСУГ, "Артлар соёл урлаг" ТББ болон Ардын урлагийн наадмуудын дэлхийн ассоциатай хамтран зохион байгууллаа.	
2.Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго-2: Хүмүүнлэг, оюунлаг хотын иргэдийг бэлтгэн, хотын соёлыг түгээн дэлгэрүүлнэ.							
2.1	Дамбадаржайлин хийдийн өмчлөлийн маргааны асуудлыг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах	-	Хэрэгжилтийн хувь	40	100	Улаанбаатар хотын Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих инкубатор төвийг Дамбадаржайлин хийдийг түшиглэн байгуулахаар төлөвлөж ажлын хэсэг 8 удаа хуралдаж 27 удаагийн үүрэг үүрэг даалгавар өгөгдсөний хэрэгжилтийг ханган ажилласан. Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын 2023.05.25-ны өдрийн 09 дүгээр хуралдааны тэмдэглэлээс холбогдох байгууллагуудад үүрэг чиглэл өгсний дагуу хийдийг ТББ-аас буцаан авах ажлыг хийсэн. Ингэснээр Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 09 дүгээр сарын 28-ний өдрийн 111 дүгээр тогтоолоор батлагдсан Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд Дамбадаржайлин хийдийг түүх соёл, шашны цогцолбор болгон хөгжүүлэх зураг төслийг боловсруулах ажлын 70.0 сая төгрөгийн төсвийг тусгуулсан.	70
2.2	Нийслэлийн харьяа Соёл, урлагийн байгууллагуудыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй болгоход хамтран ажиллах	-	Байгууллагын тоо	-	5	Улаанбаатар хотын номын сан жишиг болгож Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан 90 нэрийн номыг E+PUB хүртээмжтэй форматаар тусгай хэрэгцээт боловсролын шаардлагад тохируулан бүрдүүлж үйлчилгээнд нэвтрүүлсэн бөгөөд 4 дүүргийн номын санд нэвтрүүлэх төлөвлөлт гарган ажиллаж байна. Мөн харааны бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх танхимын орох хаалга, ариун цэврийн өрөөнд засвар хийн тав тухтай үйлчлүүлэх боломжоор хангасан. Төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой технологийн сургалтуудыг харааны бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх	30

						танхимын номын санч, харааны бэрхшээлтэй иргэдийг оролцуулан зохион байгуулсан.	
3.1	"Хотын соёл" цуврал контент бий болгосон байна. /"Улаанбаатар-2023" Зүүн Азийн залуучуудын наадмын хүрээнд/	-	Контэн тын тоо	95	105	<p>Хотын соёл, соёл, урлагийн бүтээлийг сурталчлах 22 контент бий болгож, "Хэвшил болгоё" 1 цахим аян хэрэгжүүлсэн .</p> <p>1.Чингэлтэй дүүргийн Соёлын төвөөс "Эгшиглэнт айзам аялгуу" чуулгын ахмад уран бүтээлчдийн уран бүтээлийг таниулан сурталчлах, өвлүүлэн үлдээх зорилгоор Буурал аав, Хайлуур мөрөн, Усны тунгалаг тамирын гол, Show flower зэрэг дуунуудын видео контент хийж сурталчилсан.</p> <p>2.Иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх хэвшил болгоё уриатай "Соёлын давлагаа" нийгмийн нөлөөллийн аяныг</p> <ul style="list-style-type: none"> ○ Миний соёл:Хувь хүний соёл ○ Манай соёл:Гэр бүлийн соёл ○ Бидний соёл:Байгууллагын соёл ○ Нийтийн соёл: Хотын соёл <p>дэд сэдвийн хүрээнд зохион байгуулж, тус бүр 4 нийт 16 контентыг нийгмийг соён гэгээрүүлэх чиглэлээр хувь хүн, гэр бүл, албан байгууллага, хамт олны сайн жишээг иргэд, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан түгээж сурталчлан ажиллав.</p> <p>"Хэвшил болгоё" фэйсбүүк хуудсыг нээж, одоогоор 7000 дагагч, 6,700 лайктайгаар идэвхжсэн байна. Мэдээ, мэдээллийг тухай бүрд байгууллагын пейж хуудсаар дамжуулан хүргэж байна.</p> <p>3.Багануур дүүрэг Соёлын ордноос "Хотын соёлыг түгээе" сэдэвт цахим контентийн уралдаан зохион байгуулж, "Нийтийн соёлыг түгээе" нөлөөллийн видео контентыг байгууллагын цахим хуудсаар нийтэд хүргэж, БЦС-ийн сурагчдын видео контентын хандалт 1457, ГГЦС-ийн сурагчдын видео контентын хандалт 551, Оюуны эрин ЦС-ийн сурагчдын видео контентын хандалт 1864 авсан байна.</p> <p>4. "Улаанбаатар 2023" Зүүн Азийн наадамд бүс нутгийн улс орнуудын 870 залуу тамирчин, үүнээс БНХАУ-ын 400, Монголын улсын 255 тамирчин, бусад улс орнуудаас 215 тамирчин оролцож, олон улсыг хамарсан энэхүү арга хэмжээний хүрээнд нийгмийг соён гэгээрүүлэх, хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилготой 4 контентыг бүтээж, видео контентуудыг Зүүн Азийн Залуучуудын наадмын цахим хуудсаар дамжуулан 1840 гаруй хэрэглэгчдэд хүрсэн.</p>	100

3.2	Иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх "Соёлын давалгаа" аяныг өрнүүлнэ.	40.0	Арга хэмжээ ний тоо	-	4	<p>1."Соёлын эрхийн бичгийн тандалт судалгаа" аяныг "Соёлын бүтээлч үйлдвэрлэл II", "Бүх нийтийн соёлын боловсрол", Монгол ба дэлхий дахин" хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтийг нийслэлд эрчимжүүлэх зорилгоор ЕБС-иудын ахлах ангийн сурагчдыг "Соёлын эрхийн бичиг"-ээр дамжуулан соёл, урлагийн үйлчилгээнд хамруулах арга зүйг нэвтрүүлэх ажлыг 2023.11.15-2023.11.30-ны өдрүүдэд зохион байгуулж, нийслэлийн 9 дүүрэгт 13 төр, хувийн хэвшлийн, мэргэжлийн урлагийн байгууллагын 82 удаагийн соёл, урлагийн тоглолт, үзвэр үйлчилгээ, үйл ажиллагааг 12 заал танхимаар хүргэж, Нийслэлийн 330 ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн 22552 сурагчид хамрагдсан.</p> <p>2. "Соёлын сэргэлт-2023" аяныг нийслэлийн 9 дүүрэг 204 хороонд зохион байгуулан ажиллаж байна. Хаврын аянаар нийслэлийн Баянзүрх, Налайх, Багануур, Багахангай дүүргүүдэд 2023 оны 05 сарын 27-06 сарын 06-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, аяны удирдамжид тусгагдсан дараах арга хэмжээг зохион байгуулав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийн худалдаа үйлчилгээ, • Улаанбаатар хотын музейн үзэсгэлэн, • Соёлын ажилтнуудад зориулсан чадавхжуулах сургалт, • Нээлттэй дуулах микрофон (Гадаа талбайд), • "Бүх нийтийн соёлын боловсрол" илтгэлүүд, • Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа соёмбо чуулгын тоглолтыг зэрэг соёл урлагийн олон талт үйл ажиллагааг дээрх 4 дүүргийн 10,230 иргэнд танхимаар хүргэж цахимаар мөн шууд дамжуулан ажиллав. <p>3. Улаанбаатар хотын музей 2023 онд 5 хөтөлбөрийн хүрээнд 18 удаагийн боловсролын ажил зохион байгуулж нийт 1520 хүүхэд, залуусыг хамруулсан. Үүнээс "Нийслэл хүрээ", "Улаанбаатар хотын үл хөдлөх дурсгал", "Улаанбаатар хотын түүхэн хөгжил" хөтөлбөрүүд нь уламжлалт хөтөлбөр бөгөөд Улаанбаатар хотын соёлыг сурталчлах, өсвөр үе залуучуудыг соён гэгээрүүлэх зорилготой</p> <ul style="list-style-type: none"> • "Улаанбаатарын хог хаягдал", • "Утаагүй тамхи мода биш" сэдэвт 2 	100
-----	--	------	---------------------	---	---	---	-----

						хөтөлбөрийг шинээр боловсруулан Нийслэлийн хүүхэд залуучуудын тусгай цогцолбор, 84, 21, 23, 124, 105, Эрхэм баян эрдэм, Оюунлаг, Арвис, Global, Оргил зэрэг ерөнхий боловсролын сургууль, 122, 127 цэцэрлэг, МУИС, СЭЗДС-ийн оюутнууд, нийт 1520 хүүхэд, өсвөр үе, залуучуудад хүргэсэн. 4. Иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх хэвшил болгоё уриатай "Соёлын давлагаа" нийгмийн нөлөөллийн аяныг Миний соёл:Хувь хүний соёл, Манай соёл:Гэр бүлийн соёл,Бидний соёл:Байгууллагын соёл, Нийтийн соёл: Хотын соёл сэдвүүдийн хүрээнд зохион байгуулж, нийт 16 контентыг нийгмийг соён гэгээрүүлэх чиглэлээр, хувь хүн, гэр бүл, албан байгууллага, хамт олны сайн жишээг иргэд, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан түгээж сурталчлан ажиллав.	
4.1	"Улаанбаатар" олон улсын кино наадмыг зохион байгуулах	175.0	Уран бүтээлийн тоо	6	8	"Улаанбаатар олон улсын кино наадам-15" арга хэмжээ 2023 оны 10 дугаар сарын 16-аас 22-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 12 төрөлд шилдэгүүдээ тодруулсан бөгөөд наадмын албан ёсны хөтөлбөрт Канн, Берлин, Венец зэрэг дэлхийн А зэрэглэлийн кино наадмын шагналт Монгол, Итали, Герман, Швейцар, Йордан, Вьетнам, Франц, Япон улсын 22 киног нийт 6000 гаруй үзэгчдэд толилуулсан.	100
4.2	Сонгодог урлагийн гала фестивалийг зохион байгуулахад хамтран оролцох	40.6	Уран бүтээлчдийн тоо	52	80	Сонгодог урлагийн гала фестивалийг 3 удаа зохион байгуулж, 82 уран бүтээлч оролцлоо. Үүнд: 1. "TRE TENORI" сонгодог урлагийн гурвалсан тоглолт 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр УДБЭТ-т тоглогдож, тоглолтод 20 уран бүтээлчид оролцож, 500 хүн үзэж сонирхов. 2.Гайхамшигт соёлын өргөө ТББ-тэй хамтран "Дэлхийн сонгодог Монголд" буюу "World's Classics in Mongolia" нэртэй сонгодог гурвалсан тоглолтыг Дуурь бүжгийн эрдмийн эрдмийн театрт зохион байгуулав. Тоглолтод Дуурь бүжгийн эрдмийн театрын гоцлол дуучин Ө.Цэрэнчунт, ОХУ-ын Крансноярск хотын ДБАТ-ын гоцлол дуучин Михалев Александр Геннадьевич, БНХАУ-ын Шаньси хотын Их театрын гоцлол дуучин Чжан Лей нар оролцон тоглож 3 улсын 30 уран бүтээлчид оролцож, 500 хүн үзэж сонирхов. 3. Сонгодог урлагийн содон бүтээлийг олон нийт болон жуулчдын хүртээл болгож, соёл урлагийг сурталчлах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яамны	100

						дэмжлэгтэйгээр "Lala Land" медиа арт (балетын тоглолтыг Сүхбаатарын талбайд 9 дүгээр сарын 2-ны өдөр зохион байгуулж, олон нийтэд хүргэв. Оскарын шагналт "Lala Land" киноны хөгжмийг албан ёсны эрхтэйгээр, балетын бүжгэн жүжгийг "Lala Land" медиа арт энтертайнмент-ын ерөнхий найруулагч Ц.Цолмонбуд-ын дэг найруулгаар 32 уран бүтээлч оролцож, 5000 хүнд хүргэсэн.	
5.1	"Номын баяр" арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	154.7	Оролцогчдын тоо	100,000	120,000	Улсын Их хурлын даргын ивээл дор жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг 33,34 дэх номын баяр "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2023" арга хэмжээг Соёлын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, "Номын соёлт ертөнц" ТББ хамтран зохион байгуулж, хавар, намрын номын баярт нийт 486,978 хүн оролцож, ном худалдан авах, номоо сурталчлах, бусад соёл, урлагийн үйлчилгээнд хамрагдав. Хаврын буюу 33 дахь номын баярын үеэр нийт 17 чиглэлд тус бүр 5-10 хүнтэй 300 орчим хүний бүрэлдэхүүнтэй баг, 30 гаруй төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж 236,978 хүн 3 өдрийн турш номын баярын үйл ажиллагаанд хамрагдсан байна. Намрын буюу 34 дэх номын баяр Сүхбаатарын талбайд дөрвөн өдөр үргэлжилж (оролцогчдын хүсэлтээр 1 өдөр сунган үргэлжилсэн) "Үндэсний номын баяр"-ыг "Илүү их уншъя" уриан дор зохион байгуулж, үйл ажиллагаанд 160 гаруй аж ахуйн нэгж байгууллага, 260 орчим шилдэг хэвлэн нийтлэгч, зохиолч, яруу найрагч уран бүтээлчид, 50 гаруй номын худалдаа эрхлэгч, 20,000 гаруй уншигч оролцож, давхардсан тоогоор 250,000 хүн хамрагдаж, үйл ажиллагааг үзэж сонирхов.	100
5.2	Үндэсний бичгийн өв соёл, сурвалж судалгааг сурталчлах, Үндэсний бичгээр дагнасан үзэсгэлэн арга хэмжээг зохион байгуулах	-	Арга хэмжээний тоо	1	2	1.Үндэсний 33 дахь номын баярын өдрүүдэд "Хөх бичиг" бичиг соёлын академийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлснээр үндэсний бичиг соёлын өвийг сурталчлан 230 хүнд монгол бичиг, калиграфтаар бичиж дурсгах үйлчилгээг үзүүлсэн. 2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар уламжлал болгон зохион байгуулдаг "Мөнх тэнгэрийн бичиг" монгол уран бичлэгийн олон улсын үзэсгэлэнг зохион байгуулахад хамтран оролцож, ажлын хэсгийн нарийн бичгээр ажиллав. Монгол бичиг соёлыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, уран бүтээлчид, багш, оюутан, сурагчдын шинэлэг санаа,	100

						санаачилга, авьяас чадварыг нийтэд таниулах, дэмжихэд чиглэсэн уг үзэсгэлэн 2023 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Чингис хаан музейд зохион байгуулагдаж Үзэсгэлэнд манай улсаас гадна ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улс, Бүгд Найрамдах Халимаг Улс, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орон, Шинжаан-Уйгурын Өөртөө Засах Орны уран бүтээлч, уран бичээч багш, оюутан, сурагчид 300 гаруй бүтээлээ ирүүлсэн.Энэ жил оюутны ангиллыг шинээр нэмсэн байна.	
5.3	"Гэгээн муза" театр урлагийн наадамд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах	235.0	Оролцогчдын тоо	57	62	<p>"Гэгээн муза-17" олон улсын театрын наадамд "Нэр дэвшүүлэх комисс"-ын нэгдүгээр шатны үзлэгт гадаад дотоодын нийт 68 бүтээл бүртгэгдсэнээс 23 бүтээл шалгарч, Үндсэн жүжгийн ангилал"-д" Драммын жүжгийн төрөл", "Хүүхдийн жүжгийн төрөл", "Бэсрэг жүжгийн ангилал"-д "Хоёр хүний жүжгийн төрөл", "Нэг хүний жүжгийн төрөл" гэсэн 4 төрлөөр 22 номинацид 100 гаруй уран бүтээлч өрсөлдөхөөр "Нэр дэвшигчийн гэрчилгээ"-гээ хүлээн авсан.</p> <p>Наадмын үйл ажиллагаа 2022 оны 12 дугаар сараас эхэлж, 2023 оны 10 сар хүртэлх хугацаанд үргэлжлэн "Нэр дэвшүүлэх комисс"-ийн нэгдүгээр шатны үзлэгт Монгол, Румын, Польш, Уругвай, Буркино Фасо, Итали, Герман, Солонгос зэрэг 12 орноос драмын урлагийн чиглэлээр ажиллаж байгаа театр, продакшн, чөлөөт уран бүтээлчдийн 60 гаруй бүтээлийг хүлээн авч, үзэж, шалгаруулан II шатанд 6 орноос 23 уран бүтээл нэр дэвшин өрсөлдлөө.</p> <p>Гэгээн Муза наадмын хүрээнд гадаад багш нарын мастер сургалтыг 2023.09.11-нд Итали улсын Инстабили Ваганти театрын жүжигчин, сургагч багш Никола Пианзола, Анна Дора Дорна нар "Органик боди" сэдэвт физикл сургалтыг СУИС-ийн ТУС-ийн байранд зохион байгуулж, 30 гаруй уран бүтээлч оролцлов. Мөн Говийн V Ноён хутагт Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойд зориулж "Нүүдэлчдийн соёл сэтгэлгээ мэргэжлийн театрын үндэс" сэдэвт ОУЭШХурлыг зохион байгуулж, хуралд Монгол, Энэтхэг, Бангладеш, ХБНГУ, Филлиппин, Иран зэрэг 6 орны 12 илтгэгчид оролцлоо. Наадмын үйл ажиллагааг 2023.01.15-ны өдрөөс эхлэн Гэгээн Муза Академийн https://www.facebook.com/gegeenmuza лэйж хуудас, https://www.facebook.com/profile профайл,</p>	100

						<p>https://www.instagram.com/gegeen_muza/ инстаграммаар дамжуулан сурталчлав.</p> <p>Наадмын Улаан хивсний баяр, Академийн шагнал гардуулах ёслолын ажиллагааг 2023.09.17-ны өдөр СТӨ-нд зохион байгуулагдаж, 1520 хүн оролцож, Гэгээн Муза Академийн https://www.facebook.com/gegeenmuza пэйж хуудас, НЗДТГазар, НСУГ-ын пэйж хуудсаар шууд нэвтрүүлж, нийт нэр дэвшсэн 19 бүтээл, шагнал гардуулах ёслолын ажиллагааг 16,000 гаруй нийслэлийн иргэд үзэгчдэд хүргэв.</p>	
5.4	“Улаанбаатар-2023” Зүүн азийн залуучуудын наадмын урлагийн хэмжээг байгуулах Соёл, арга зохион	-	Арга хэмжээ ний тоо	-	4	<p>1.Улаанбаатар-2023” Зүүн азийн залуучуудын наадмын хаалтын “Мөрөөдлийн галаа асаа” үйл ажиллагааг Д.Сүхбаатарын талбайд хоёр хэсэгтэйгээр зохион байгуулсан бөгөөд арга хэмжээг 7 орны 842 тамирчин, зохион байгуулах хорооны 52, арын алба болон сайн дурын 1990 ажилтан болон 2000 гаруй хүүхэд залуучууд үзэж сонирхсон.</p> <p>2.Нийгмийг соён гэгээрүүлэх, хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх 4 контент бүтээж, Зүүн Азийн Залуучуудын наадмын цахим хуудсаар дамжуулан 1840 гаруй хэрэглэгчдэд хүрсэн.</p> <p>3. Зүүн азийн наадмын оролцогчдод зориулсан урлагийн тоглолтыг хариуцсан зохион байгуулж, 1200 хүнийг хамруулсан.</p> <p>4. Зүүн Азийн наадмын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон байгууллагын пэйж хуудсаар түгээн сурталчилж ажилласан.</p>	90
5.5	“UB Dance” чөлөөт бүжгийн тэмцээнийг хамтран зохион байгуулах	-	Оролцогчдын тоо	200	250	<p>“UB Dance” чөлөөт бүжгийн тэмцээнийг зохион байгуулах удирдамж, төлөвлөгөөг боловсруулан, дүүргүүдийн Соёлын ордонд хүргүүлж, санхүүжилтийн асуудлыг НЗДТГ-т танилцуулж нэгдсэн байдлаар хийх асуудал шийдвэрлэгээгүй тул дүүрэг тус бүр чөлөөт бүжгийн тэмцээнийг зохион байгуулж ажиллав. 7 дүүргийн хэмжээнд бүжгийн 7 төрлийн арга хэмжээг зохион байгуулж, нийт 2198 хүн оролцсон байна.</p>	50
5.6	Улаанбаатар хотын бүжгийн спортын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах	-	Оролцогчдын тоо	100	200	<p>Улаанбаатар хотын бүжгийн спортын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах удирдамжийг боловсруулсан 7 дүүргийн Соёлын ордонд хүргүүлсэн. Санхүүжилтийн асуудлыг шийдвэрлээгүй тул хэрэгжилт хангагдаагүй болно.</p>	10

5.7	“Морин хуур” оны шилдэг дуу шалгаруулах 35 дахь наадам зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажиллах	10.0	Уран бүтээлийн тоо	-	180	“Морин хуур” оны шилдэг дуу шалгаруулах 35 дахь наадамд мэргэжлийн дуу, хүүхдийн дуу, рок Поп болон орчин цагийн хөгжмийн урсгалын дуу, нийтийн дуу гэсэн дөрвөн төрөлд нийт 202 дуу бүртгүүлснийг эхний шатны шүүгчдэд сонсгож 25 дуу ГАЛА тоглолтод шалгарч 4 төрөлд шилдгүүдээ шалгаруулсан. Тус наадмыг МҮОНТВ-ээр сурталчилсан бөгөөд Соёлын төв өргөөнд 1600 гаруй хүн үзэж сонирхсон.	100
5.8	Д.Лувсаншаравын нэрэмжит Хүүхдийн найрал дууны 29 дэх удаагийн наадмыг зохион байгуулах	145.1	Оролцох хамтлагийн тоо	80	85	Д.Лувсаншаравын нэрэмжит Хүүхдийн найрал дууны 29 дэх удаагийн наадмын гала тоглолт 10 дугаар сарын 26-нд боллоо. Наадмын анхан шатны шалгаруулалтад нийслэлийн найман дүүргийн 75 сургуулийн 5100 гаруй сурагч оролцсон бол хоёрдугаар шатанд 20 сургуулийн 1200 орчим хүүхэд оролцож, шилдгүүдээ тодруулав. Наадмын 2 шатанд давхардсан тоогоор 95 сургуулийн 6300 хүүхэд оролцож бөгөөд Гала тоглолтыг MNB2 сувгаар шууд дамжуулан үзүүлж, тоглолтыг 3000 гаруй хүн урилгаар үзэж сонирхсон байна. Нийт 95 сургуулийн 6300 хүүхэд оролцож, 3000 хүн урилгаар үзэж, нийт 9300 хүн оролцсон байна.	100
5.9	Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулна.	188.5	Хэрэгжилтийн хувь	100	100	Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан “Нэгдүгээрт хүүхэд” уриатай “Монгол хүүхдүүд” баярын зохион байгуулалт, тайз, урлагийн тоглолт, соёлын арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажилласан. Монголын уламжлалт тоглоом наадгайтай холбоотой шинэ дүрийг бий болгох зорилготой “Монгол хүүхдүүд” бренд үүсгэхээр ажиллаж тус өдөрт 6 шинэ дүрийг танилцуулсан. Дээрх арга хэмжээнүүдэд 6550 уран бүтээлч, уран бүтээл оролцож 21100 иргэд, жуулчид үзэж сонирхлоо.	100
5.10	Үндэсний их баяр наадмын хүрээнд “Улаанбаатарын үдэш” шоу тоглолтыг зохион байгуулна.	200.0	Хэрэгжилт, хувь	100	100	Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны 2023 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн 04 тогтоолын дагуу “Улаанбаатарын үдэш” арга хэмжээний гүйцэтгэх продюсерээр газрын дарга Э.Цэнд-Аюуш ажиллаж “Эх орон” дуугаараа Төрийн соёрхол хүртсэн “Хурд” хамтлаг жанжин Д.Сүхбаатарын талбайд тоглолтоо зохион байгуулж найруулагчаар Хурд хамтлагийн продюсер МУГЖ Д.Отгонбаяр ажилласан.Тоглолтод Хурд хамтлаг, Чоно хамтлаг, Андууд хамтлаг, S4 хамтлаг, Drumstik хамтлаг, Уухай хамтлаг, R&N хамтлаг, Voice шоуны шилдэг оролцогчид, дуучин Э.Агиймаа, Т.Цогсогмаа, И.Мишээл нар оролцож Фантастик продакшны жүжигчин, кино зохиолч,	100

						продюсер СТА Б.Барслхагва, жүжигчин СТА Э.Одбаяр нар хөтлөгчөөр ажилласан. Тоглолтод 60 гаруй уран бүтээлчид оролцож 10000 гаруй иргэд, жуулчид үзэж, UBS телевизээр шууд дамжуулсан.	
5.11	Нийслэл Улаанбаатар хотын 384 жилийн ойн өдрийн Соёл, урлагийн арга хэмжээг зохион байгуулна.	170.0	Хэрэг жилт, хувь	100	100	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 384 жилийн ойн хүндэтгэлийн концерт нийслэлийн Соёлын төв өргөөнд зохион байгуулагдлаа. Концертыг нийслэлийн үе үеийн удирдлагууд, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, харьяа байгууллагууд, дүүрэг, хороодын удирдлагууд, албан хаагчид, нийслэлийн иргэд нийт 1700 зочид урилгаар үзсэн. Нийслэлийн ойд зориулсан хүндэтгэлийн концертыг нүүдлийн болон суурин соёлтой, дөрвөн улиралтай хотын ондоошлыг илтгэн харуулах өвөрмөц онцлогтойгоор зохион байгуулсан.	100
5.12	Шинэ жилийн "Мөнгөн шөнө" баярын үйл ажиллагааг зохион байгуулна.	577.8	Хэрэг жилт, хувь	100	100	"Улаанбаатарын мөнгөн шөнө" шинэ жилийн арга хэмжээг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж, иргэд олон нийтэд хүргэх үүрэг бүхий Ажлын хэсгийг Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1305, А/1331 тоот захирамжаар баталсан. НСУГ ажлын хэсгийн нарийн бичгээр ажиллаж ажлын хэсэгт орсон 33 байгууллагаас санал авч нэгтгэн, танилцуулга хийж, шаардлагатай үед цахим болон танхим хэлбэрээр хурал зохион байгуулж ажиллав. Дүүргүүд өөрсдийн орчин байршилд дүүргийн иргэдэд зориулсан шинэ жилийн арга хэмжээг зохион байгуулав. Нийт 10 шинэ жилийн арга хэмжээг 100,000 хүн үзэж сонирхов.	100
5.13	Цагаан уул хайрын яруу найргийн наадам зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажиллах	8.0	Арга хэмжээ ний тоо	-	1	Залуу уран бүтээлчид, яруу найрагчдыг дэмжих, тэдний уран бүтээлийг үнэлж, нийтийн хүртээл болгох, олон нийтэд сурталчлах, Монгол хэлний үгийн яруу сайхан өв уламжлалыг түгээн дэлгэрүүлж, олон нийтэд сурталчлах, хүүхэд залуучуудад таниулах зорилгоор Монгол Улсын Соёлын Гавьяат зүтгэлтэн, "Болор цом"-ын эзэн Арлааны Эрдэнэ-Очирын нэрэмжит 22 дахь удаагийн "Цагаан-Уул" наадмын хоёрдугаар шат 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдөр Соёлын төв өргөөнд зохион байгуулагдлаа. Наадамд 300 гаруй уран бүтээлчийн 1000 гаруй уран бүтээлээс 24 яруу найрагч шалгаран хайрын шүлгээ өргөсөн бөгөөд "Гүн утга" уран бүтээлийн нэгдлийн яруу найрагч Г.Хашбаатар түрүүлж "Цагаан-Уул" цомын эзэн болж, тус наадмыг 1856 хүн үзэж сонирхов.	100

6.1	Нийслэлийн соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулах	97.8	Зохион байгуулах арга хэмжээ ний тоо	-	1	<p>- НИТХ, НЗДТГ, Нийслэлийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ болон Нийслэлийн Соёл урлагийн газраас Улаанбаатар хот ЮНЕСКО-ийн "Бүтээлч хотуудын сүлжээ"-нд нэгдсэнтэй холбогдуулан 2023 оны 12 дугаар сарын 1-ний өдөр "Бүтээлч үйлдвэрлэлээр хотын эдийн засгийг нэмэгдүүлэх боломж" форумыг зохион байгууллаа.</p> <p>Тус форумаар "Улаанбаатар хот ЮНЕСКО-ийн Бүтээлч хотуудын сүлжээнд бүртгүүлсэн үр дүн, ач холбогдол", "ЮНЕСКО-ийн Бүтээлч хотуудын хамтын ажиллагаа, эдийн засгийн ач холбогдол", "Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бодлогод ЮНЕСКО-ийн Бүтээлч хотуудын сүлжээ нь дэмжлэг болох нь", "ЮНЕСКО-ийн Бүтээлч хотуудын сүлжээгээр эдийн засгаа тэлэх боломж" гэх сэдвүүдийн хүрээнд ярилцаж, ардын бүжгийн үзүүлбэр, эсгий урлал, үндэсний хувцасны үзэсгэлэн зохион байгуулав.</p> <p>-Соёлын бүтээлч сарын хүрээнд "Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн форум 2023" арга хэмжээг зохион байгуулж, 12 салбарын 90 гаруй чиглэлийн 320 төлөөлөл цуглаж, соёлын салбарт хэрэгжиж байгаа хууль тогтоомж, цаашдын төлөвлөгөө, бодлогын хүрээнд зөвлөлдөж "Бүтээлч байдал, мэдлэг туршлага", "Соёлын засаглал, эрх зүйн шинэчлэл", "Соёлын хүртээмж, хөрөнгө оруулалт", "Дижитал шилжилт, шинэ боломж" сэдвээр 4 салбар хэлэлцүүлгийг хийв.</p>	100
7.1	Нийслэлийн Соёл, урлагийн байгууллагууд болон "Улаанбаатар театр"-ын хүний нөөцийг бүрдүүлж чадавхжуулах	-	Хэрэгжилтийн хувь	100	100	<p>1. Нийслэлийн харьяа мэргэжлийн урлагийн байгууллагын хүний нөөцийг нэмэгдүүлэх санал дэвшүүлж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, Засаг даргын 2023 оны А/263 дугаар захирамжаар Улаанбаатар театрын бүтцийг 146 хүний орон тоогоор батлуулж, хүний нөөцийн бүрдүүлэлтийг нээлттэй сонгон шалгаруулалтаар хийж байна.</p> <p>2. Соёлын сэргэлт-2023 аяны хүрээнд дүүргийн соёл, урлагийн байгууллагуудын ажилтан, албан хаагч, ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан, соёл, урлагийн чиглэлийн багш нарт зориулсан чадавхжуулах сургалтыг харьяа соёлын орднуудын байранд үе шаттайгаар зохион байгуулж, 7 дүүргийн 284 соёлын ажилтан албан хаагчдыг хамруулж, ур чадвар, арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан.</p> <p>3. Төрийн бүтээмж-бүтээлч албан хаагч сургалтад нийслэлийн харьяа соёл урлагийн байгууллагуудын нийт 385</p>	100

						ажилтан албан хаагч хамрагдсанаас Улаанбаатар театрын бүрэлдэхүүн 100 хувь хамрагдсан болно.	
8.1	Дүүргийн Соёлын төв, Соёлын орднуудын үйлчилгээний стандартын шаардлагад нийцсэн орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	-	Дэмжлэг үзүүлсэн соёлын ордны тоо	-	7	Дүүргийн Соёлын төв, соёлын орднуудын орчин нөхцөлтэй танилцах ажлыг 2023 оны 10 дугаар сард зохион байгуулж, Соёлын дэд сайд Д.Батбаяраар ахлуулсан сайдын ахлах зөвлөх Оюунбилэг, Газрын дарга, Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг нийслэлийн 7 дүүргийн Соёлын орднуудын барилга, байгууламж, орчин нөхцөлтэй газар дээр нь танилцаж, дүүрэг тус бүрд санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажилласан. Баянзүрх дүүргийн Соёлын ордны барилга төвийн дулаан шугамд холбогдсоор үйлчилгээний стандартын шаардлагад нийцсэн орчныг бүрдүүллээ.	80
9.1	Гоожингийн өндрийн өмчлөлийн асуудлын маргааныг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах	-	Хэрэгжилтийн хувь	-	100	"Гоожингийн өндөр"-ийн өмчлөлийн асуудлын маргааныг шийдвэрлэх асуудлаар Нийслэлийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн А/1032 дугаартай захирамж гарсан. Нийслэл Улаанбаатар хотын түүх, соёлын үл хөдлөх дурсгал, Ерөнхий сайд Т.Намнансүрэнгийн амьдарч байсан 2 давхар барилга (Гоожингийн өндөр)-ийг хамгаалалтад авах тухай тус захирамжийн хүрээнд ажлын хэсэг байгуулагдан ажиллах явцад иргэн Б.Мөнх-Эрдэнэ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд А/1032 дугаартай захирамж нь хууль бус гэж үзэн гомдол гаргасан. "Гоожингийн өндөр" хэмээх барилга нь иргэн Б.Мөнх-Эрдэнийн эзэмшлийнх болох нь 3 шатны шүүхээр тогтоогдсон бөгөөд тус иргэнтэй зөвшилцөн Нийслэлийн хамгаалалтад авах төсвийг Нийслэлийн 2024 оны төсвийн тодотголд тусгуулахаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Харин сэргээн засварлах ажлын зураг төслийг боловсруулах 70.0 сая төгрөгийг Нийслэлийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгуулсан.	100
10.1	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын аппликэйшнийг сурталчлах ажлыг зохион байгуулах	-	Хэрэгжилтийн хувь	50	100	"Mongol Events" төслийн хүрээнд Нийслэлийн нутаг дэвсгэрт байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудыг QR кодоор танилцуулах аппликэйшн бүтээж, нийт 217 дэсийн 479 дурсгалын мэдээллийг оруулан бүртгэлжүүлэн мэдээллийн танилцуулга хийсэн. Апплекэйшнийг байгууллагад албан ёсоор хүлээлгэн өгөөгүй байна.	80
10.2	Google art and Culture цахим хөгжүүлэлтэд нийслэлийн соёл	9.3	Хамруулах	-	11	Соёлын аялал жуулчлалын эргэлтэд оруулах ажлын хүрээнд Соёлын өвийн үндэсний төв, Google-ийн монгол дахь албан ёсны төлөөлөгч ИТЕХ компанитай хамтран нийслэлд байх	30

	урлагийн байгууллагуудын мэдээллийг оруулах		байгууллагын тоо			музейнүүдийг Google art-руу оруулах бэлтгэл ажлыг ханган фонарамм зураг авах төлөвлөгөө гарган, гурван талт гэрээний төсөл боловсруулан ажиллаж байна.	
11.1	"Бүтээлч хот" хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг эхлүүлэх	-	Хэрэгжилтийн хувь	-	100	-Соёлын өвөрмөц, дахин давтагдашгүй хэв шинжийг агуулсан "Бүтээлч хот" хэлбэрээр хөгжүүлэх үзэл баримтлал боловсруулах ажлын хүрээнд ЮНЕСКО-ийн албан ёсны пэйж хуудас https://en.unesco.org/creative-cities/home , creativitycities@unesco.org цахим хаягт хандаж ЮНЕСКО-ийн Бүтээлч хотуудын сүлжээ (UCCN)-нд нэгдэж орох хүсэлт илгээсэн. Улаанбаатар ЮНЕСКО-гийн "Бүтээлч хотуудын сүлжээ"-нд гар урлал, ардын урлагаар нэгдэн орсон анхны хот болж 2023 оны 12 дугаарын 01-ний өдөр батламжаа гардаж авсан. "Бүтээлч хотуудын сүлжээ"-нд Улаанбаатар хот нэгдэн орсноор ЖДҮҮ эрхлэгчид шинэ түвшинд гарч, дэлхийн зах зээлд соёлын бүтээлч үйлдвэрлэлийг таниулаад зогсохгүй хотын эдийн засаг, тогтвортой хөгжилд чухал нөлөө үзүүлэх боломж бүрдэж байна.	100
3. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ							
<i>Зорилт 3. Салбарын хүний нөөцийг бэлтгэх, даатан сургах, мэргэшүүлэх тоотолцоо бий болгож, тэднийг дэмжих, нийгмийн баталгааг сайжруулах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.</i>							
3.1	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллах	305,5	Батлагдсан төсөв	251,004,500	305,471,700	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, өр, авлага үүсгэхгүй ажиллаж, зардлыг зүй зохистой зарцуулан ажиллаж, хуулийн хугацаанд тайлагнаж ажиллаж байна. НСУГ-н даргын 2023 оны А/63 дугаар тушаалаар "Санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд тавигдах нийтлэг шаардлага"-ыг батлуулан, төрийн байгууллагын зарим үйл ажиллагааг төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлсний дараа тайланг өгөхдөө баримтлах, бүрдүүлэх баримтын жагсаалтыг гаргаж, тайланг шаардлагад нийцүүлэн хүлээн авч байна.	100
3.2	Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2023 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл,	-	Төсөл хөтөлбөрийн тоо	3	5	Нийслэлийн Засаг даргын соёл, урлагийн чиглэлээр иргэдийг хөгжүүлэх зорилтын 2023 онд зохион байгуулах зарим арга хэмжээний жагсаалт А/373, сургалт зохион байгуулах тухай А/374, хөрөнгө гаргах тухай А/163, А/372, А/470, А/471, А/530, А/766, А/661, А/686, А/710, А/1242, А/1250, А/1322, А/1343, А/1361 захирамжуудыг батлуулан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон	100

	арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж хугацаанд нь чанартай гүйцэтгэх					холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж хугацаанд нь чанартай гүйцэтгэн тайланг тухай бүрд нь гарган ажиллаж байна.	
3.3	Байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулах	Улсын төсөв	Албан хаагчдын тоо	-	15	Байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалтын төлөвлөгөөг 2023 оны 01 сарын 24-ний өдөр, Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийг 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/64 дугаар тушаалаар шинэчлэн тус тус батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Албан хаагчийн сургалт, ажлын байрны ур чадварын сургалт, хувь хүний хөгжлийн сургалтаар 3 ангилан 20 удаагийн сургалт зохион байгуулахаар төлөвлөж нийт 26 удаагийн сургалтад давхардсан тоогоор 522 албан хаагч хамрагдсан байна. "Удирдлагын академи"-ийн төрийн албан хаагчийг мэргэшүүлэх анхан шатны сургалтад 1, дунд хугацааны давтан сургалтад 2, эрхэлсэн түшмэлийн сургалтад 2 албан хаагч хамрагдаж төгссөн. Албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг бүрдүүлэхээр Соёлын Яамны 2024 оны Хөрөнгө оруулалтын төсөлд санал боловсруулж хүргүүлсэн. 1 албан хаагчид 200,000 төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.	100
3.4	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих	-	Тарих модны тоо	1072	2100	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр", 2021 оны 58 дугаар зарлигийн хүрээнд хэрэгжүүлэх "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хаврын мод тарих, арчлах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хамт олноороо 2022 онд тарьсан модны арчилгаа, цэнэг усалгаа нөхөн тарилтыг хуваарийн дагуу 2023 оны 05 дугаар сарын 13, 14 -ны өдрүүдэд хийж гүйцэтгэв. Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо Айцын амны 100 га талбайд байгуулагдаж буй "Ойн төгөл"-д 2022 онд нийт 31 ширхэг мод тарьсан бөгөөд 100 хувийн ургалттай байна.	100

						Намрын мод тарих арчлах хуваарийн дагуу 10 дугаар сарын 14-ны өдөр албан хаагчид очин арчлалт хийсэн. Нийслэлийн соёл, урлагийн 11 байгууллагын ажилтан, албан хаагчид 2023 онд нийт 2155 мод тарьсан.	
3.5	Нийслэлийн Засаг даргыг шүүхэд итгэмжлэлээр төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу оролцох, үр дагаврыг нийслэлийн Засаг даргын өмнө бүрэн хариуцах	-	Хэрэг жилтийн хувь	-	100	Нийслэлийн Засаг даргыг шүүхэд итгэмжлэлээр төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу оролцох тухай асуудал гараагүй болно.	100
3.6	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах, албан хаагчдыг сургалтанд хамруулах	-	Сургалтын тоо	1	3	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн харьяа соёл, урлагийн байгууллагуудын албан хаагчид, дүүргийн соёлын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, 216 албан хаагчийг хамруулж, мэдлэг, мэдээллийг хүргэж ажиллав. "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль" шинэчлэн батлагдсантай холбогдуулан танилцуулах сургалтыг зохион байгуулж байгууллагын нийт мэргэжилтнүүд 100 хувь хамрагдаж, нийслэлийн харьяа 11 байгууллагын удирдлага, албан хаагчдад цахим сургалтыг зохион байгуулав. Соёлын яам, Авилгатай тэмцэх газартай хамтран "Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албан хаагчийн ёс зүй, соён гэрээрүүлэх үйл ажиллагааны талаар мэдлэг мэдээллийг дээшлүүлэх" сургалтыг зохион байгуулж, тус газрын албан хаагчид болон нийслэлийн харьяа соёл, урлагийн 11 байгууллагын 12 удирдах албан тушаалтан, 126 албан хаагч, нийт 138 хүн хамруулж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах талаар үүрэгжүүлж, хэрэгтэй мэдээллийг олгов.	100
3.7	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн	-	Үйл ажиллагааны тоо	-	3	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх 5 зорилго, 8 арга хэмжээний төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллалаа.	

	<p>аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн харэгжилтийг ханган ажиллах, соёлын бүтээгдхүүн үйлчилгээнд нөлөөллийн үйл ажиллагааг тусгах</p>				<p>1.Үндэсний хэмжээнд зохион байгуулсан "Ажлын байр-бэлгийн дарамтгүй орчин" сарын аянд нийслэлийн харьяа соёл, урлагийн байгууллагууд нэгдэж, "Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх нь" сургалтыг зохион байгуулж 12 байгууллагын удирдлага, албан хаагчид 58 хүн хамрагдав.</p> <p>- Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд заасан чиг үүргээ биелүүлэхэд нь мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр бэлтгэсэн видео мэдээллүүдийг байгууллагын ажилтан албан хаагчдад таниулан, мэдээлэл хүргэн ажилласан.</p> <p>2.Жендерийн үндэсний хорооноос 2023.11.25-2023.12.10 өдөр хүртэл Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяныг "Хүндлэл-хамгийн тод гэрэл" уриан дор зохион байгуулагдаж Нийслэлийн соёл, урлагийн 11 байгууллагууд аянд нэгдсэн.</p> <p>Аяны хүрээнд 2 постер бэлтгэн, байгууллагын болон харьяа 11 байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд түгээсэн.</p> <p>Жендерийн ажлын хүрээнд 2023 онд "Эрчүүдээ дуулья", урлагийн тоглолт зохион байгуулж 245 хүн, 24 сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулж 3000 гаруй хүн хамрагдсан.</p>	100	
3.8	<p>Нийслэлийн төрийн өмчит соёл урлагийн байгууллагуудад эрсдэлийн үнэлгээ хийж эрсдэлийн ангилалд хамаарах объектын жагсаалтыг батлуулах, эрсдэлийн үнэлгээ, хяналт шалгалтын мэдээллийг цахим системд бүртгэх, дүн шинжилгээ хийх /Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.5/</p>	Улсын төсөв	Эрсдэлийн үнэлгээ хийсэн объектын тоо	24	34	<p>Салбарын хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд ямар чиглэлийн байгууллагуудад эрсдэлийн үнэлгээ, хяналт шалгалт хийх талаар хэлэлцэж, соёлын хяналтад орж байгаагүй музей, номын сан, соёлын төв, ордуудыг хамруулан давхардсан тоогоор 18 хуулийн 99 заалт, 6 стандартын 34 заалт, 2 дүрэм, журмын 7 заалтыг мөрдүүлэн ажиллав. Мөн 2023 оноос эхлэн дээрх д байгууллагууд аас гадна мэргэжлийн урлагийн байгууллага, боловсролын байгууллагуудын номын сангуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхээр шийдвэрлэсэн. Шинээр хяналтын объект нэмэгдэхтэй холбоотой хуулийн заалтуудыг судлан үзэж 2 шалгуур үзүүлэлт, 1 хяналтын хуудсыг тус тус шинээр боловсруулан Соёлын Яамны Салбарын хяналтын газарт хүргүүлсэн.</p> <p>Улсын байцаагчийн норм, нормативыг батлуулах ажлын хүрээнд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдаж буй байгууллагад ажиллах хугацааг нэмэх саналыг оруулж</p>	80

						<p>улсын байцаагч нэг байгууллага дээр хяналт шалгалт хийх хугацааг ажлын 5 өдөр байсныг 6-7 өдөр байхаар санал хүргүүлж ажилласан.</p> <p>Холбогдох хууль, дүрэм журмын дагуу соёл, урлагийн нийт 45 байгууллагын үйл ажиллагаанд 4 шалгуур үзүүлэлтээр эрсдэлийн үнэлгээ хийхэд бага эрсдэлтэй 9, дунд эрсдэлтэй 35, их эрсдэлтэй 1 байгууллага тус тус үнэлэгдсэнийг эрсдэлийн үнэлгээний нэгтгэлийг хурлын тэмдэглэлийн хамт Соёлын яамны Салбарын хяналтын газарт хүргүүлж ажилласан.</p>	
3.9	Нийслэлийн төрийн өмчит соёл урлагийн байгууллагуудад төлөвлөгөөт шалгалт, тандалт судалгаа, салбарын сургалтыг хийх	Улсын төсөв	Тухайн жилд эрсдэлийн ангилал буурсан объектын тоо	27	37	<p>1. Салбарын хяналтын чиглэлээр 4 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн.</p> <p>2. Соёлын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/79 тоот "Гадаадад үзэсгэлэн гаргах эрх олгох тухай" тушаалын дагуу Катар улсын Доха хотноо "ON the move" үзэсгэлэнд Уран зургийн галлерейн сан хөмрөгөөс 4 бүтээл дэглэгдсэн. Тус бүтээлийг монголоос тээвэрлэх болон буцааж хүлээн авах үеийн сав баглаа боодол, үзмэрүүдийн аюулгүй байдалд хяналт тавин ажилласан.</p> <p>3. Богд хаан музейгээс Чингис хаан үндэсний музейд хосгүй үнэт үзмэр зөөн шилжүүлэх үеийн явцад хяналт тавин ажилласан. Дээрх хяналт шалгалтаар зөрчил илрээгүй болно.</p> <p>4. Иргэн Б.Мөнхсайханаас ирүүлсэн Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах, "Бурхан багш"-ийн цэцэрлэгт хүрээлэнг арчиж тордохгүй, дотор нь байгаа ном, судар устах эрсдэлтэй байна гэх гомдол, мэдээллийн дагуу 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдөр тус цэцэрлэгт хүрээлэнд очиж холбогдох асуудлыг тодруулан, хяналт тавин ажилласан. Хяналтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд 02/47 тоот албан бичгээр, зөвлөмж хүргүүлэн ажилласан. Мөн гомдол гаргагч иргэнд зөвлөмж хүргүүлэн ажилласан тухай 02/48 тоот албан бичгийг хүргүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.</p> <p>5. Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргын өгсөн үүргийн дагуу Богд хааны ордон музейн үйл ажиллагаатай танилцаж, музейн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсаар төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг Салбарын хяналтын газрын улсын ахлах байцаагчидтай хамтран 2023 оны 5</p>	100

					<p>дугаар сарын 01-нээс 02-ны өдрүүдэд хийж гүйцэтгэж, хяналт шалгалтаар 12 зөрчил дутагдлыг илрүүлэн, зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр мэргэжил арга зүйгээр ханган, шалгалтын дүн мэдээг музейн удирдлага болон ажиллагсдад танилцуулж, өөрсдийн зүгээс авч хэрэгжүүлэх боломжтой ажлуудыг хийж байгууллагын дотоод хяналтыг тогтмолжуулах талаар зөвлөгөө өгсөн.</p> <p>6.Төлөвлөгөөт тандалт судалгаа: Соёлын яамны Салбарын хяналтын газраас нийслэлд байх түүх соёлын үл хөдлөх дурсгалын байршил, хил зааг, талбай эзлэхүүн, тоо хэмжээ, тэдгээрийн эзэмшил, ашиглалт, өмчлөлийн эрхийн талаарх тандалт судалгааг ирүүлэх тухай 3/3/2 дугаартай албан бичиг ирүүлсэн. Тус албан бичгийн дагуу 9 дүүргийн 35 түүх соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг хавсралт хүснэгтийн дагуу гаргаж нэгтгэн Салбарын хяналтын газарт хүргүүлж ажилласан.</p> <p>7. Төлөвлөгөөт салбарын сургалт: Салбарын хяналтын газраас нийслэлд үйл ажиллагаа эрхэлж буй соёлын байгууллагуудын дунд "Эрсдэлийн үнэлгээ, шалгуур үзүүлэлт" хэлэлцүүлэг зохион байгуулахаар төлөвлөсөн. Тус хэлэлцүүлэгт хамрагдах нийслэлд үйл ажиллагаа эрхэлж буй 25 байгууллагын 31 албан хаагчийн судалгааг гарган, хамруулж, сургалтыг хамтран зохион байгуулсан.</p>		
3.10	Өөрийн эрхлэх чиг үүргийн хүрээнд салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэх	-	Боловсруулсан саналын тоо	-	1	<p>-Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 06 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг олгох, хэрэглэх, түүнд хяналт тавих журам"-ын 2.1-д заасны дагуу тус байгууллагад шилжин ирж ажиллаж буй Соёлын хяналтын улсын байцаагч Б.Өнөржаргалын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгийг олгох тухай 02/74 тоот албан бичгийг илгээж, улсын байцаагчийн эрх сунгагдсан.</p> <p>-Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээг тогтоох, сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, олон нийтэд мэдээлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах үүрэг бүхий Ёс зүйн дэд хороог Газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/60 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хорооны дарга, 2 гишүүнтэйгээр шинэчлэн байгуулсан.</p>	100
4.ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ							

4.1	"Улаанбаатар-2023" Зүүн азийн залуучуудын наадмын соёл, урлагийн хөтөлбөрийг хамтран зохион байгуулах	-	Хэрэгжилтийн хувь	-	100	"Улаанбаатар 2023" зүүн Азийн залуучуудын наадмын хаалтын "Мөрөөдлийн галаа асаа" хаалтын тоглолт "Сүхбаатарын талбай"-д зохион байгуулагдаж хөгжим, тайз, гэрлийн дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан. Ёслолын үйл ажиллагааны нэгдүгээр хэсэг болох уг үйл ажиллагаанд оролцогч орнуудын баг тамирчид, дасгалжуулагчид болон хөгжөөн дэмжигч, спорт сонирхогчид өргөнөөр ирж оролцлоо. Хаалтын хоёрдугаар хэсэг болох "Улаанбаатарын үдэш" шөнийн шоу тоглолтыг хамтран зохион байгуулан ажиллав. Тоглолтонд: • Үндэсний урлагийг их театрын бүжигчид • Хөтлөгч Алтаншагай, уран бүтээлч Наран, Баярцэцэг, Наагий, Энгүүн, Big Gee, Vandebo, Seks Tsagaan Bogd, Gangbay, Young Mo'G, Ahuna, Shuwu, Epoch, Batuh нар оролцов.	100
4.2	Харьяалах нутаг дэвсгэрийн Соёл, урлагийн байгууллагын статистик мэдээллийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр цуглуулах, нэгтгэн дүгнэх, тайлагнах, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах	879.8	Мэдээллийн санд бүртгэгдсэн байгууллагын тоо	-	48	Соёл, урлагийн байгууллагын 2021 оны үйл ажиллагааны тайлан, ажиллагчдын мэдээг 11, хөрөнгө санхүүгийн мэдээг 1 маягтаар хугацаанд нь хүргүүлсэн. Улирал тутмын мэдээг 2023 оны 1,2,3,4 дүгээр улирлын байдлаар гаргаж хүргүүлсэн.	100
5.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖ							
5.1	Нийслэлийн Засаг даргын Тамгын Газрын хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын 2022 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах төлөвлөгөө гаргаж, хэрэгжилт, үр дүнг	-	Хэрэгжилтийн хувь	Ажил сайжруулах	Хангалттай	Нийслэлийн Засаг даргын Тамгын Газрын хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын 2022 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах ажлын хэсгийг Захиргаа, удирдлагын хэлтсийн даргаар ахлуулан байгуулж ажлын төлөвлөгөө гарган батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагуудын ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр 2023 оны хагас жилээр "Хангалттай" үнэлгээ авсан.	100

	дүгнэн тайлагнаж ажиллах						
5.2	Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр хийж, түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулах	-	Судалгааны нэгтгэл	2	4	Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг зохион байгуулсан ажил арга хэмжээний 10%-иас авахаар төлөвлөсөн бөгөөд иргэд жуулчдад зориулан зохион байгуулагдсан 25 арга хэмжээнээс Номын баяр, Хүүхдийн баяр, Даншиг наадам-Хүрээ цам, Нүүдэлчин дэлхийн соёлын арга хэмжээнүүдийн үеэр сэтгэл ханамжийн судалгааг 400 хүнээс авч нэгтгэсэн, Соёлын эрхийн бичгийн тандалт судалгааг үйлчилгээнд хамрагдсан	100
5.3	Төсвийн хөрөнгөөр хийгдсэн судалгаа, шинжилгээ, ажлын тайлан, холбогдох бусад материалыг албан ёсны цахим хуудсанд нээлттэй байршуулах	-	Хэрэг жил тийн хувь	100	100	Судалгааны нэгдсэн систем болох Sudalгаа.gov.mn -д Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн судалгаа шинжилгээний ажил болох "Нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх түүх соёлын бүртгэл судалгаа", "Туулын хар түнэ" түргэний голын балгас малтлага судалгааны тайланг байршуулж ажилласан	100
5.4	"Цахим улаанбаатар" төсөл, "digital first" аяны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, цахим хөгжлийн багц хуулийг сурталчлан таниулах, хуульд заасны дагуу нээлттэй өгөгдөл, мэдээлэл, нийтийн мэдээллийн сангийн хэрэгжилтийг хангуулах	-	Хэрэгжил тийн хувь	100	100	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 187 дугаар тогтоолоор "Соёл, урлагийн сургалт, цэнгээнт үйлчилгээний журам"-д өөрчлөлт орж 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс диско клуб, билльярд, боулинг, дэлгэцийн гольф, автомат тоглоомын газар, караоке, тайчих газруудын зөвшөөрлийг тус газраас олгохгүй болсон. Дараах үйл ажиллагаануудад онлайн бизнес төвөөр дамжуулан зөвшөөрөл олгож байна. Үүнд: 1.Соёл, урлагийн (дуу хөгжим, бүжиг, драм, кино, загвар, хөтлөгч, жүжигчин, тайзны яриа, илтгэх урлаг, уран зураг, фото зураг, төрөл бүрийн хатгамал, нүүр будаг, хувиргалт) сургалтын газрын үйл ажиллагаа, 2.Дэлгэцийн болон дүрс бичлэгийн бүх төрлийн кино үзвэрийн газруудын үйл ажиллагаа, 3.Соёлын төв, үзвэр үйлчилгээний газрын зөвшөөрлийг олгоход хамтран оролцож байна. Онлайн бизнес төвөөр 3 төрлийн зөвшөөрөл олгож байгаа бөгөөд жилийн эцсийн байдлаар сургалт зохион байгуулах 3 байгууллагын хүсэлтийг шийдвэрлэж дахин хүсэлт ирээгүй байна.	100

5.5	Хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар нийслэлийн хороодын хэсгийн ахлагчийн системээр дамжуулан ирүүлсэн зөрчлийн мэдээллийг өдөрт нь баггаан хүлээн авч ажлын 5 хоногийн дотор шийдвэрлэх ажлыг зохион байгуулах.	-	Хэрэгжилтийн хувь	-	100	Нийслэлийн хороодын хэсгийн ахлагчийн системээр дамжуулан ирүүлсэн зөрчлийн мэдээлэл тус газарт ирээгүй.	100
5.6	Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээг цахимжуулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авч, байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулах.	-	Хэрэгжилтийн хувь	100	100	Онлайн бизнес төвөөр дамжуулан дараах зөвшөөрлийг олгож байна. Үүнд: 1.Соёл, урлагийн (дуу хөгжим, бүжиг, драм, кино, загвар, хөтлөгч, жүжигчин, тайзны яриа, илтгэх урлаг, уран зураг, фото зураг, төрөл бүрийн хатгамал, нүүр будаг, хувиргалт) сургалтын газрын үйл ажиллагаа, 2.Дэлгэцийн болон дүрс бичлэгийн бүх төрлийн кино үзвэрийн газруудын үйл ажиллагаа, 3.Соёлын төв, үзвэр үйлчилгээний газрын зөвшөөрлийг олгоход хамтран оролцож байна. Арга зүйн 3 удаагийн сургалтыг байгууллагын хүсэлтээр зохион байгуулсан. Нийслэлийн Соёл, урлагийн газар веб хуудас хаагдсан байсныг 2023 оны 5 дугаар сард нээлгэж, мэдээллийг шинэчлэн, баяжуулж, идэвхтэй удирдлагаар ханган 33600 дагагчтай болж, пейж хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд мэдээ мэдээллийг түгээн ажиллаж байна. Байгууллагын үйл ажиллагааны нээлттэй байдлыг ханган байгууллагаас зохион байгуулсан ажлын мэдээ, тайланг мэдээллийн самбарт нээлттэй байршуулж, веб хуудсанд шилэн дансны үйл ажиллагааг нээлттэй, ил тод байдлаар мэдээлж байна.	100

5.7	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч хэвших, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгайлсан арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж ажиллах.	-	Хэрэгжилтийн хувь	100	100	Байгууллагын хэмжээнд нийт 18 өргөдөл гомдол ирснийг хуулийн хугацаанд 100 хувь шийдвэрлэж ажилласан. Иргэдээс ирсэн өргөдөл, гомдолд албан бичгээр хариу өгсөн 6, цахимаар хариу өгсөн 4, утсаар хариу өгсөн 7, иргэнтэй биеэр уулзаж хариу хүргүүлсэн 1 байна. Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг хандалтаар нь авч, үзвэл: Урлаг соёлын арга хэмжээний тухай 4 (22.3%) ажилд шилжих, дэвшин ажиллах тухай 2(11.2%), ажлаас чөлөөлөгдөх тухай 2 (11.2), нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны тухай 1 (5.6 %) хүрээлэн буй орчны тухай 1 буюу (5.6%) хөшөө, түүх соёлын дурсгалт зүйлийн тухай 1 буюу (5.6%) боловсролын салбарын үйл ажиллагааны тухай 1 (5.6%) цалинтай чөлөө хүсэх тухай 1 (5.6%) ээлжийн амралтын тухай 1 (5.6%) 10 зар сурталчилгаа, мэдээллийн самбарын тухай (5.6%) согтууруулах ундааны зөвшөөрөл, худалдаа, үйлчилгээний тухай (5.6%) нийслэлийн Засаг даргын Хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагааны тухай 1 (5.6%) соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагааны тухай 1 (5.6%) байна.	100
НЭМЭЛТ АЖЛУУД							
1	Байгууллагын үйл ажиллагаанд чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандарт нэвтрүүлэх	-	Боловруулах бичиг баримтын тоо	-	11	Нийслэлийн Соёл, урлагийн газрын даргын 2023 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн А/07 тоот тушаалаар чанарын менежментийн тогтолцооны MNS ISO9001:2016 стандартыг нэвтрүүлэх ажлын хэсгийг байгуулсан. Газрын үйл ажиллагаанд чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандарт нэвтрүүлэх ажлыг 03 дугаар сараас 06 сар хүртэлх хугацаанд зөвлөх багш Ц.Батгэрэлтэй хамтран чанарын бодлого зорилтоо тодорхойлж, төлөвлөлтөө гарган, гадаад, дотоод орчны шинжилгээ хийж, процессийн эмхтгэл нэгтгэн, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, удирдлагын дүн шинжилгээний журам, дотоод аудитын журам, үл тохирлын журам боловсруулж, сургалтын хэрэгцээгээ тодорхойлон 11 бүлэг бүхий чанарын гарын авлага бэлтгэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хянуулж байна.	90
2	Баримтат өвийн бүртгэл мэдээллийн нэгдсэн жагсаалтад	8.5	Албан хаагчдын тоо	-	765	"Монгол улсын баримтат өвийн бүртгэл мэдээллийн нэгдсэн жагсаалтад баримтат өвийг бүртгэх аргачлал" сэдэвт сургалтыг 9 дүүргийн 204 хорооны 765 албан хаагчдыг	100

	баримтат өвийг бүртгэх аргачлал" сэдэвт сургалт зохион байгуулах					чадавхжуулах зорилгоор Нийслэлийн Засаг даргын тамгын газрын дэмжлэгтэйгээр, Соёлын яам, Юнескогийн Монголын үндэсний комисс, Соёлын өвийн үндэсний төв, Үндэсний төв номын сан, Нийслэлийн соёлын төв өргөө, СУИС-тай хамтран зохион байгуулсан.	
3	"Тэнгэрийн хүү" яруу найргийн Улсын хоёрдугаар наадамд дэмжлэг үзүүлэх	5.0	Арга хэмжээ ний тоо	-	1	Ш.Сүрэнжавын нэрэмжит "Тэнгэрийн хүү" яруу найргийн Улсын хоёрдугаар наадмыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажилласан.	100
4	Соёл, урлагийн байгууллагуудын өдөрлөг зохион байгуулах	42.6	Оролцогчдын тоо	-	500	Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй соёл, урлагийн байгууллагуудын нэгдсэн өдөрлөг 2023 оны 04 дүгээр сарын 14, 15-ны өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд "Улаанбаатарын хаврын баяр 2023"-ын хүрээнд зохион байгуулагдлаа. Үндэсний эв нэгдэл, монгол соёлыг сурталчилсан олон талт ажил зохион байгуулах, хүмүүнлэг, оюунлаг хотын иргэдийг бэлтгэхэд болсворол, соёлын байгууллагын хамтын ажиллагааг өрнүүлж хотын соёлыг төлөвшүүлэх зорилтын хүрээнд Соёлын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газартай хамтран зохион байгуулсан ба нийт 27 байгууллагын удирдлагууд, 500 гаруй уран бүтээлчид, соёлын ажилтан, албан хаагчид оролцож хоёр өдрийн турш нийт 10,000 гаруй нийслэлийн иргэд, хүүхэд, залуучууд, жуулчид үзэж сонирхлоо.	100
5	Соёл, урлагийн сургуулиудын нэгдсэн өдөрлөг зохион байгуулах	55.1	Оролцогчдын тоо	-	1200	Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй Соёл, урлагийн сургуулиуд болон мэргэжлийн сургалтын төвүүдийн нэгдсэн өдөрлөг 2023 оны 04 сарын 12-ны өдөр Д.Сүхбаатарын талбайд "Улаанбаатарын хаврын баяр 2023"-ын хүрээнд зохион байгуулагдлаа. Өдөрлөгт 200 гаруй багш, 1000 гаруй оюутан, сурагчид оролцсон бөгөөд 3000 орчим нийслэлийн иргэд, хүүхэд, залуучууд, жуулчид үзэж сонирхлоо.	100
6	Төрийн хүндэтгэлийн тоглолтыг Сүхбаатарын талбайд зохион байгуулах	200.0	Уран бүтээлчдийн тоо	-	500	Тулгар төрийн 2232, Их Монгол Улс байгуулагдсаны 817, Үндэсний эрх чөлөө, Тусгаар тогтнолоо сэргээн мандуулсаны 112, Ардын хувьсгалын 102 жилийн ой, Үндэсний их баяр наадмын Төрийн хүндэтгэлийн тоглолт Нийслэлийн Соёлын төв өргөө болон Д.Сүхбаатарын талбайд 2023 оны 07 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулагдсан.	100

						<p>Төрийн хүндэтгэлийн тоглолтын Ерөнхий найруулагчаар Хөдөлмөрийн баатар, ардын жүжигчин, Төрийн хошой шагналт Н.Жанцанноров ажилласан.</p> <p>"Эх орон" сэдвийн хүрээнд Монгол Улсын 21 аймгийн үндэсний бахархал, өв соёл, онцлогийг агуулсан найруулгатайгаар зохион байгуулсан. Соёлын төв өргөө, мэргэжлийн урлагийн байгууллагуудын 500 гаруй уран бүтээлчид оролцож 5000 гаруй хүн иргэд жуулчид үзэж сонирхсон.</p>	
7	"Интро 2023" электро хөгжмийн наадам зохион байгуулах	59.9	Үзэгчдийн тоо	-	25000	<p>Иргэд жуулчдад зориулсан нийтийг хамарсан урлагийн тоглолт, үйл ажиллагааг зохион байгуулах арга хэмжээний хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 06 дугаар сарын 22-ний А/686 "Интро 2023" электро хөгжмийн наадмын ажлын хэсгийн захирамж гарсан.</p> <p>Интро олон улсын электроник хөгжмийн наадам зохион байгуулах ажлын нарийн бичгээр ажиллаж 2023 оны 6 дугаар сарын 23,24,25-ны өдрүүдэд Монгол шилтгээн цогцолборт зохион байгуулж 3 өдрийн туршид 25000 гаруй иргэд үзэж сонирхлоо.</p> <p>Интро олон улсын электроник хөгжмийн наадмыг албан ёсны эрхтэйгээр гурав дахь жилдээ EMM нэгдлийн дор X-CORE хамтран зохион байгуулав.</p> <p>Энэ жилийн наадам зөвхөн DJ гэж хязгаарлахгүйгээр дотоодын гар, электроник хөгжимтэй хослуулсан дуучин уран бүтээлч нартай хамтарч байгаагаараа онцлогтой.</p> <p>Хөгжим техник, гэрлийн иж бүрдэл, тайзны хашилт /65 ширхэг/-аар дэмжлэг үзүүлж мэргэжилтнүүд 3 өдөр хяналт тавин ажилласан.</p>	100
8	"Даншиг наадам-Хүрээ цам 2023" зохион байгуулах	460.0	Оролцогчдын тоо	-	310	<p>"Даншиг наадам-Хүрээ цам 2023" наадмын хүрээнд урлагийн тоглолтыг бүрэн хариуцаж 2 өдөр дараалан нийслэлийн 9 дүүргийн 290 гаруй уран бүтээлчид, өвлөн уламжлагч, ардын авьяастануудын тоглолтыг, 2023 оны 08 дугаар сарын 05-ны 20:00 цагт монгол туургатны 20 гаруй уран бүтээлчдийг хамруулсан 3 хэсгээс бүрдсэн шоу тоглолтыг зохион байгуулан ажилласан.</p> <p>Нийслэлийн соёл, урлагийн өргөөг хариуцан 9 дүүргийн 290 гаруй ардын авьяастнуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн, Монгол туургатан уран бүтээлчдийг байрлуулан тоглолтод оролцуулах, наадмын үйл ажиллагаатай</p>	100

					танилцуулах, хэвлэл мэдээлэлд ярилцлага, мэдээлэл өгөх зэрэг ажлуудыг зохион байгуулсан.	
9	Автомашингүй өдөр 2023 арга хэмжээний зохион байгуулалтад ажиллах	28.2		-	2023 оны 09 дүгээр сарын 23-ны "Автомашингүй өдөр 2023" арга хэмжээний тайзны зохион байгуулалт, урлагийн тоглолтыг хариуцан ажилласан. Сүхбаатарын талбайд цугласан иргэд, олон нийтэд эрүүл аж төрөх соёл, идэвхтэй хөдөлгөөний ач холбогдлыг уриалж, нийтийг хамарсан уралдаан тэмцээн, соёл, урлаг, эрүүл мэндийн арга хэмжээг Нийслэлийн Эрүүл мэндийн газартай хамтран зохион байгууллаа. Залуучууд, иргэдэд эерэг хандлага түгээх зорилготой Юнайтед Артс групптэй хамтран #OPENMIC эвент арга хэмжээг зохион байгуулж, 22 дуулаач оролцож "Автомашингүй өдөр# эмээ, охины дуу" -г 66М хүн үзэж, 14М хүн эерэг сэтгэгдэл бичиж, 4М хүн бусдад түгээсэн байна.	100
10	"Соёлын бүтээлч сар" арга хэмжээ	60.0			"Соёлын бүтээлч сар" аяны хүрээнд соёлын өвийн тухай ярилцлага, цуврал нэвтрүүлэг бэлтгэх ажлыг Нью глобал трейдинг ХХК, нээлтийн шууд дамжуулалт хийх ажлыг ОБ глобал медиа ХХК, соёлын өвийг сурталчлах, баримтжуулах, түгээлтийн олон хэлбэрийн бүтээгдхүүнийг бэлтгэж нийлүүлэх ажлыг Ган үзэг мэдээллийн үндэсний холбоо ТББ-уудад гэрээлэн гүйцэтгүүлж ажиллав.	100
11	"Соёлын бүтээлч сар" арга хэмжээ	400.0	Оролцогчдын тоо	-	22552	100

						цуглаж, соёлын салбарт хэрэгжиж байгаа хууль тогтоомж, цаашдын төлөвлөгөө, бодлогын хүрээнд зөвлөлдөж "Бүтээлч байдал, мэдлэг туршлага", "Соёлын засаглал, эрх зүйн шинэчлэл", "хүртээмж, хөрөнгө оруулалт", "Дижитал шилжилт, шинэ боломж" гэсэн 4 салбар хэлэлцүүлэгт оролцов.	
12	Б.Шаравын нэрэмжит мэргэжлийн дуучид, үндэсний хөгжимчдийн олон улсын 3 дугаар уралдаанд дэмжлэг үзүүлэх	34.4	Оролцогчдын тоо	-	120	Монгол Улсын Төрийн дээд шагнал, тэргүүн зэргийн "Чингис хаан" одонт, Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Урлагийн гавьяат зүтгэлтэн, хөгжмийн зохиолч Бямбасүрэнгийн Шаравын нэрэмжит "Мэргэжлийн дуучид, үндэсний хөгжимчдийн олон улсын III уралдаан" 2023 оны 11 дүгээр сарын 08-13-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж, Монгол Орос, Хятад зэрэг улс орнуудаас 120 мэргэжлийн уран бүтээлч оролцлоо. Уралдааны хүндэтгэлийн тоглолт 2023 оны 11 дүгээр сарын 13-нд Улсын Дуурь Бүжгийн Эрдмийн театрт зохион байгуулагдаж шилдгүүдээ шалгаруулж, гуравдугаар уралдааны тэргүүн байрын Гранпри шагнал 10 мянган ам долларын шагналыг Нийслэлийн Засаг дарга буюу Улаанбаатар хотын захирагч " Үндсэний агуулга шингэсэн уран бүтээлийг дэмжих зорилт"-ын хүрээнд шийдвэрлэсэн.	100
13	Нийслэлийн харьяа соёл, урлагийн байгууллагуудын ажилтан, албан хаагчид, уран бүтээлчид, соёлын ажилтнуудын оны шилдгүүдийг тодруулах "Алтан хангарьд" наадмыг зохион байгуулах		Оролцогчдын тоо	-	218	Нийслэлийн харьяа соёл, урлагийн байгууллагуудын ажилтан, албан хаагчид, уран бүтээлчид, соёлын ажилтнуудын оны шилдгүүдийг тодруулах "Алтан хангарьд" наадмыг тус газраас санаачлан Монгол Улсын Соёлын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэмжлэгтэйгээр анх удаа зохион байгууллаа. Улаанбаатар хотын соёлын салбар, соёл, урлагийн байгууллагуудын хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, албан хаагчдын мэргэшлийн түвшинг үнэлэх, урамшуулах, сайн туршлагыг сурталчлах, алдаршуулах, манлайллыг түгээх зорилгоор 11 байгууллагын 218 ажилтан албан хаагчдыг хамруулан зохион байгуулагдсан тус наадамд 12 номинациар шилдгүүдийг тодруулан алдаршуулсан.	100
14	Нөхөн бүрдүүлэлтэд архивын баримтыг шилжүүлэх	-	Төрийн архивт шилжүүлсэн баримтын тоо		267	Тус газар нь 2023 онд төрийн архивт байнгын баримтуудаа шилжүүлэх хуваарийн дагуу Нийслэлийн Архивын газрын Мэргэжил, арга зүйн зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 03 дугаар хурлаар байгууллагын 2014-2021 оны архивын баримтын данс, бүртгэл, жагсаалтыг хэлэлцэн нийслэлийн Архивын газрын дэргэдэх Баримт нягтлан	100

					шалгах арга зүйн комиссын 2023 оны 05 дугаар хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн болно. Иймд хурлын тэмдэглэлээр өгсөн чиглэлийн дагуу засвар, өөрчлөлтийг хийж байгууллагын 7 төрлийн данс, нийт 1056 хадгаламжийн нэгжийн бүртгэлийг эцэслэн газрын даргаар батлуулж Нийслэлийн Архивын газарт хүргүүлэв.	
15	"Соёлын сэргэлт" аян	-	Оролцогчдын тоо	10230	<p>Үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх, бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх, соёлын салбарын ажилтнуудыг чадавхжуулах, иргэдэд хүргэх соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор "Соёлын сэргэлт-2023" аяныг нийслэлийн 9 дүүрэг 204 хороонд зохион байгуулан ажиллалаа.</p> <p>Соёлын сэргэлт аянаар дараах арга хэмжээг зохион байгуулав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийн худалдаа үйлчилгээ, -Улаанбаатар хотын музейн үзэсгэлэн, -Соёлын ажилтнуудад зориулсан чадавхжуулах сургалт, -Нээлттэй дуулах микрофон (Гадаа талбайд), -“Бүх нийтийн соёлын боловсрол” илтгэлүүд, -Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа соёмбо чуулгын тоглолт зэрэг соёл урлагийн олон талт үйл ажиллагааг дээрх 4 дүүргийн 10,230 иргэдэд танхимаар хүргэж цахимаар болон шууд дамжуулан ажиллав. 	100

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ

Бүлгийн дугаар	Хэрэгжүүлэх арга хэмжээ	100 хувь хэрэгжсэн	90 хувьтай хэрэгжсэн	80 хувьтай хэрэгжсэн	70 хувьтай хэрэгжсэн	50 хувьтай хэрэгжсэн	30 хувьтай хэрэгжсэн	10 хувьтай хэрэгжсэн	Хугацаа болоогүй, Хэрэгжээгүй
I	2	2							"
II	26	18	1	3	1		2	1	"
III	10	9				1			"
IV	2	2							"
V	7	7							"
Дүн	47	38	1	3	1	1	2	1	"
Нэмэлт ажил	15	15							"
Нийт	62	53	1	3	1	1	2	1	"

Хэрэгжилтийн дундаж хувь: 91.9%

Нэмэлт ажлын хэрэгжилтийн дундаж хувь 100%

Нэгдсэн дундаж хувь 93.8%

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.МӨНХЧУЛУУН

БОЛОВСРУУЛСАН: ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТ, МЭДЭЭЛЭГ ТЕХНОЛОГИ, ЦАХИМЖИЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Д.АМГАЛАН

